

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ХАРЬЯА ХОЛБОО, НАВИГАЦИ,
АЖИГЛАЛТЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ,
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2022.11.01

Улаанбаатар хот

ИНЕГ-ын Дотоод аудитын албаны даргын баталсан 2022 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн “Холбоо, навигаци, ажиглалтын албаны үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай” 10/22 тоот удирдамжийн хүрээнд Холбоо, навигаци, ажиглалтын албаны үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны менежер Ө.Мөнгөнжигүүр, аудитор А.Мөнх-Эрдэнэ, Ц.Оюут, О.Сэндэр, ИНУТ-ийн Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлагын албаны мэргэжилтэн Э.Энхболд нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2022 оны 9 дүгээр сарын 23-ны өдрөөс 2022 оны 10 дугаар 14-ний өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Холбоо, навигаци, ажиглалтын албаны 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны харилцах дансны үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримт бүрдүүлэлт, захиргаа хүний нөөцийн үйл ажиллагаа, мөрдөгдөж буй дүрэм, журмын хэрэгжилт, шилэн дансны хуулийн хэрэгжилт зэргийг нягталж шалгахад гадна зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Дотоод, аудит хяналт шалгалтаар ХНАА-ны 2022 оны харилцах дансны баримт, бараа материал сэлбэг хэрэгслийн орлого, зарлагын баримтыг шалгахад нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт хангалтгүй, и-баримтгүй 5 иргэн, аж ахуй нэгжийн 8.6 сая төгрөгийн зөрчил илэрснийг анхаарах шаардлагатай.

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2013 оны 12 дугаар сарын 17-ны А/735 дугаар тушаалаар Агаарын хөдөлгөөний үйлчилгээний алба, Техник хангалт үйлчилгээний алба, Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны ээлжийн ажилтнуудад сар бүр цай, кофе, сахарын зориулалтаар нэг ажилтанд хөнгөлөлт олгохоор зөвшөөрсөн ба одоогийн бүтцэд эдгээр албадуудын нэршил өөрчлөгдсөн тул уг тушаалыг шинэчлэн батлуулах шаардлагатай.

Дотоод аудит, хяналт шалгалтын хугацаанд хамаарах буюу 2021 болон 2022 онуудад 13 ажилтанд дотоод томилолтын төсвийн дагуу олгосон нийт 10,546,500 /арван сая таван зуун дөчин зургаан мянга таван зуу/ төгрөгийг анхан шатны баримтгүй бүртгэсэн нь татвараас хасагдах зардлын шаардлага хангаагүй.

ХНАА-ны цаг ашиглалт, ирцийн бүртгэлийг түүвэрлэн Захиргаа хүний нөөцийг хэсэг, Санхүү хангамжийн хэсэг болон Техник төлөвлөлтийн хэсгийн 2022 оны 2, 3 дугаар сарын цагийн тооцоог төхөөрөмжтэй тулган шалгахад цагийн тооцоо баримтад байхгүй, байсныг шалгалтын явцад нөхөн бүрдүүлсэн. Цаг бүртгэлийн төхөөрөмжөөс ажилтнуудын ирсэн, явсан цагийг шалгахад цаг бүртгэл хангалтгүй буюу хоцордог, эрт гардаг зөрчил түгээмэл гарч байна.

ХНАА-ны 2021, 2022 онуудын албан томилолтын тооцоог шалгахад төлбөрийн баримтыг бүрдүүлээгүй (И-баримт) зардалд бүртгэсэн нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-т заасныг зөрчсөн. Тус зөрчил 2022 оны 02 дугаар улирлаас засагдсан байна.



Шалгалтаар ХНАА-ны 2021, 2022 онд бараа материал, сэлбэг нийлүүлсэн нийлүүлэгч нарын судалгаа, бүртгэлийг СХХ-ийн дарга болон хангамжийн мэргэжилтэн (google drive)-аар хөтөлж ирсэн боловч ЖУ-17-ын 5.4-т заасны дагуу чанар, үнийн судалгаа хангалттай хийгдээгүй байна.

Мөн 2022 оны харилцах дансны гүйлгээнээс 1 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 38 худалдан авалтын харьцуулалт, үнийн судалгаа хийсэн эсэхийг шалгахад 30-д нь хийгдээгүй байгаа нь дээрх журмын 5 дугаар бүлгийн 5.1-д заасныг хэрэгжүүлээгүй.

“Их өлгий” радиолокаторт нөөцөд байршуулахаар “interface Module 471676” дугаартай 202,450,000 төгрөгийн үнэ бүхий сэлбэгийг 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 521/4/000001793 дугаартай зарлагын баримтаар зарлагдсан боловч сэлбэгийг зарцуулаагүй, шалгалтын явцад буцаан ХНАА-руу ирүүлж байгаа гэсэн тайлбар өгсөн нь тус албаны ЖУ-17 R01 -ийн 8 дугаар бүлэг, 9 дүгээр бүлэгт заасан заалт, ИНЕГ-ын НБББББ-ийн 4.3-т заасан Бараа материалын бодлого, горимуудыг зөрчсөн.

ХНАА-ны бараа материал, сэлбэг хэрэгслийн орлого, зарлагын баримтуудыг шалгахад тус албаны ЖУ-17 R01 журмын 10 дугаар бүлэгт заасан Сэлбэг зарцуулалтын тайланг санхүүгийн баримтад хавсаргаагүй байгаа нь ИНЕГ-ын НБББББ-ийн 4 дүгээр бүлгийн 4.3-т заасан “Бараа материалын бүртгэл” хэсгийн бараа материалын бүртгэлийн бодлого, горимын шалгуурыг хангахгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгаж байна.

Байгууламжийн сэлбэгийн хангалт, түүний нөөцийг бүрдүүлэх журам (ЖУ-17 R01)-ын 8 дугаар бүлгийн 8.2-т ...Үйлдвэрлэлийн хэсгүүдийн ажлын байранд шуурхай ажиллагааг хангах зорилгоор байршуулсан сэлбэг, материалыг агуулахад байршуулсантай адилтгах ба СХХ-ийн хангамжийн мэргэжилтэн нь сар бүр бүртгэлийг Хавсралт 4-ийн дагуу гарган, шалгаж хяналтыг гүйцэтгэнэ...гэснийг мөрдөөгүй.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн **13 дугаар зүйлийн 13.1.4** дэх заалтыг зөрчиж “Алтан богочи Секьюрити” ХХК, “Найдвартай барс” ХХК-иудад тус бүр 2.0 сая төгрөгийн гүйлгээг зардлын дансанд бүртгэж байна.

Дорноговь аймгийн Сайншанд дахь ОУӨХ-т ашиглаж буй УАЗ 220692-033 маркийн 0537 УНӨ дугаартай автомашины шатахууны тооцооны баримтыг 2022 оны 01 дүгээр сараас 8 дугаар сар хүртэл шалгахад шатахууны орлогын баримт нь (И-баримт) А-92 шатахуун байхад жолоочийн замын хуудас, шатахууны зарлагын баримт нь А-80 шатахуун хэрэглэснээр тооцоо хийсэн нь ИНЕГ-ын НБББББ-ийн 4.3.2-т заасан бодлого, горимыг зөрчсөн.

Холбоо, навигаци, ажиглалтын алба нь шилэн дансанд 2022 оны 8 сарын байдлаар 108 мэдээлэл байршуулахаас 1 мэдээлэл хуулийн хугацаа хоцроосон. Мэдээллийн үнэн зөв байдлыг шалгахад тухай бүр мэдээлэх 2022 онд байгуулсан худалдах, худалдан авах 12 гэрээ, 3 тушаалыг мэдээлээгүй.

Төлөвлөгөөний хэрэгжилт нь 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 53.63%-тай ба бүрэн хэрэгжиж дууссан 5, хэрэгжилтийн шатанд 6, хугацаа болоогүй 1 арга хэмжээ тус тус байна. Төлөвлөгөөнд бүрэн хэрэгжүүлж дуусгахаар тусгасан 12 арга хэмжээнээс 6 арга хэмжээ /2, 5, 6, 7, 9, 11/-ний хэрэгжилт нь зорилтот түвшинд хүрээгүй, хэрэгжилт удаашралттай байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Холбоо, навигаци, ажиглалтын албанд 19 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА